

Орон бүсний пролетариат нар нэгдэгтүн!

АНХДУГААР ТАВАНЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь жилдээ № 78 (2382) 1974 оны 10 дугаар сарын 17 ПҮРЭВ

САРАТОВЫН СИСТЕМ

ЗХУ болон ах дүү социалист орнуудад үйлдвэрийн бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх талаар удирдлагын дэвшилтэй хоёр систем хэрэглэж байна.

Үүний нэг нь согоггүй (гологдолгүй) бүтээгдэхүүн үйлдвэрлэх саратовын систем юм. Энэ системийг анх 1955 онд ЗХУ-ын Ижил мөрний харийн Саратов хотын нисэх онгоцны үйлдвэрийнхэн санаачилжээ. Саратовын системийн үндсэн зорилт нь ажил гүйцэтгэгчийг хийсэн хөдөлмөрийнхөө чанарыг бүрэн хариуцдаг болгон хүмүүжүүлэх, бүтээгдэхүүн нь «онцсайн» чанартай байж анхны үзлэгээр хүдээлгэн өгөхөд оршино.

Энэ системийн зохион байгуулалтын үндэс нь ажил төрлийн хувийн хариуцлагын зарчим дээр үндэслэх бөгөөд ажилчнаас үйлдвэрийн дарга хүртэл бүх нийтийг хамарсан чанарын үр ашигтай шуурхай хяналт шалгалт юм. Согоггүй бүтээгдэхүүн үйлдвэрлэх системийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхийн тулд юуны өмнө чанар дээшлүүлэх бүрэн төлөвлөгөө боловсруулах, хөдөлмөр зохион байгуулалтыг зөв тогтоож, үйлдвэрлэлийн байр, хэсэг, дамжлага бүрт чанарын хяналтыг тогтмол болгох шаардлагатай.

Ажилчдын мэргэжлийг дээшлүүлэх, үйлдвэрийн газрын хууль болсон техникийн баримт бичиг, технологийн горимыг нарийн сахиулах, социалист уралдааныг зөв хослон «дээд зэргийн чанарын төлөө» сэтгэл санааны болон материаллаг урамшил, нэмэгдэл цалин тогтоох, чанар дээшлэхэд холбогдсон дэвшилт арга барил, технологи, шинэ техникийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, хөдөлмөрийн сахилга бат, ажлын цаг ашиглалтыг сайжруулах зэрэг арга хэмжээ багтдаг. Аливаа ажлын болон үйлдвэрийн бүтээгдэхүүний чанар бол түүний гүйцэтгэж хийж байгаа тодорхой хүнээс шууд шалтгаалдаг. Иймээс хүн бүрийн хөдөлмөрийг нийт хийсэн ажил болон үйлд-

вэрлэсэн бүтээгдэхүүнд анхны үзлэгээр хүдээлгэж өгсөн чанар сайтай бүтээгдэхүүний эзлэж байгаа хувийн жин хичнээн байгаагаар үнэлж цалинг түүнтэй уялдуулан олгодог нь саратовын системийн гол онцлог юм.

Үүнд үйлдвэрлэлийн гүнд ажилладаг мастер, бригадын дарга, ээлжийн ахлагч, чанар шалгагч нарын үүрэг роль асар их юм. Эдгээр хүмүүс ажлын дамжлага бүрт тавих хяналтыг тогтмол шуурхай болгож, ажилчин бүрт хяналтын карт хөтлөн, өөрсдөд нь хийсэн бүтээгдэхүүндээ «хувийн тэмдэг» тавих эрх олгон, чанарын шуурхай зөвлөлгөөнийг 7 хоног бүр хийж, үйлдвэрийн захиргаа, ҮЭ-ийн байгууллагаас чанарт нөлөөлж байгаа доголдол саатлын шалгааныг нарийн судлах, дахин давтахгүй байх бололцоог хангах, стандарт техникийн нөхцөл, ажлын зураг, загварын чанар, түүнийг мөрдөх ажилд онц анхаарах ёстой.

Бүтээгдэхүүний чанарыг сайжруулах шилдэг хэлбэр болсон энэ системийн бас нэг онцлог нь инженер техникийн ажилтны чанарын үзүүлэлтийг тогтмол дүнгэж, тэдний идэвх санаачлагыг өндөржүүлэх явдал аж.

Тус аймгийн зарим үйлдвэрийн газарт бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэхтэй холбогдсон зөв эхлэлтүүд гарч байна.

Аймгийн «Анхдугаар таван жил» сонинны үйлдвэр чанарын талон бий болгож ажилчид бүрт өгч ажилласан явдал согоггүй бүтээгдэхүүн гаргахад зохино нөлөөг үзүүлж байна. Мөн чанарын уралдаан, өдөрлөг, үзэсгэлэн зэрэг нь саратовын системийг нэвтрүүлэх нэг чухал хэсэг билээ.

Манай нөхцөлд энэ системийг үйлдвэр аж ахуй, үйлчилгээ зэрэг аль ч салбарт нэвтрүүлж болох юм.

Иймээс согоггүй бүтээгдэхүүн үйлдвэрлэх дэвшилт аргыг амьдрал үйлдвэрлэлд бүтээлчээр нэвтрүүлэх явдал үйлдвэрийн захиргаад ҮЭ-ийн байгууллагуудын чухал зорилт мөн.

ЭРХЭМ ДЭЭД ЗОЧНОО ИХ АМЖИЛТААР УГТАНА

5 сарын ажил илүү хийнэ

Манай ард түмний итгэлтэй сайн танил х а м гийн эрхэм анд хүндэт нөхөр, ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, улс түмний хоорондын энх тайвныг бэхжүүлэхийн төлөө о л о н улсын Лениний шагналт Л. И. Брежнев манай оронд айлчлан ирэх болсон нь бид бүхний баяр бахдлыг төрүүлж байна.

Манай бригадын хамт олон 1973 оны барилга угсралтын төлөвлөгөөг 15 хувиар давуулж, хөдөлмөрийн бүтээмжийг 39 хувиар дээшлүүлсэн амжилтаараа БНМАУ-ын барилгын аварга бригад гэдэг хүндэт цолоор саяхан шагнагдсан юм.

Аж ахуйн тооцоотой нэгдсэн бригадын барилгачид бид эрхэм дээд зочноо ирэх баярт өд-

рийг угтаж УАА-г удирдах газрын үйлдвэрийн баазын 20 машины гарааш, уурын зуухыг ашиглалтанд өгснөөр V таван жилийн төлөвлөгөөний эхний 4 жилд 5 сарын ажил илүү хийхээ илэрхийлж байна.

БНМАУ-ын барилгын аварга бригадын дарга, Аймгийн 5 удаагийн аварга барилгачин

Д. НАМСРАЙ

СААЛЬ СҮҮНИЙХЭЭ ДЭЭЖЭЭР

МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид, Засгийн газрын урилгаар ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Л. И. Брежнев тэргүүтэй ЗХУ-ын нам, засгийн төлөөлөгчид МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны хагас зуун жилийн ойн баяр ёслолд оролцохоор сайхан эх оронд маань айлчлан ирэх гэж байгаа баярт мэдээг мянга мянган малчид, саальчдынхаа нэгэн адил би өндөр сэтгэлээр хүлээн авлаа.

Коммунизмын орны элч төлөөлөгч Л. И. Брежневийг айлчлан ирэх баярт өдрийг угтаж сааль сүү-

нийхээ төлөвлөгөөг хугацаанаас нь өмнө биелүүлж ХАА-н үйлдвэрлэлд илгээлтээр гарсан залуу саальчдад ажлынхаа арга туршлагыг эзэмшүүлэх ажилдаа улам амжилт гаргана.

Батсүмбэрийн САА-н саальчдын зөвлөх багш, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар

А. АВИРМЭД

Гар ажиллагааг хөнгөвчилнө

Манай ард түмний дотны анд нөхөр, ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Л. И. Брежнев тэргүүтэй ЗХУ-ын нам, засгийн төлөөлөгчид удахгүй эх оронд маань айлчлан ирэх гэж байгаад би туйлын их баяртай байна.

Нөхөр Л.И. Брежневийн энэ айлчлал нь Монгол-Зөвлөлтийн ард түмний мөнхийн ган бат найрамд-

лыг улам зузаатган бэхжүүлж, манай хоёр орны найрамдал, хамтын ажиллагааны түүхийг шинэ агуулгаар баяжуулах нь дамжиггүй. ЗХУ-ын нам, засгийн төлөөлөгчид айлчлан ирэх тэр өдрийг угтаж би аймгийн хэмжээний нийтийн хоолны газруудын тогооч нарыг энэ жилийн төлөвлөгөөгөө жигд ханган биелүүлсэн байхыг уриалан мах хэм-

нэсэн 20 нэр төрлийн шинэ хоолыг, хоолны мэргэжилтэн Ч. Мөнхдалайтай хамтран хийхээс гадна мах ногоо хэрчигч хариул шинээр санаачлан ашиглалтанд оруулснаар гар ажиллагааг хөнгөвчлөн хөдөлмөрийн бүтээмжийг 5 дахин нэмэгдүүлнэ.

БНМАУ-ын Худалдааны гавьяат ажилтан, мастер тогооч Б. ДАШЗЭВЭГ

Ах дүү Курганы төлөөлөгчдөд баяр хүргэе!

КУРГАНЫ ЗОЧИД МАНАЙ АЙМАГТ

Монгол-Зөвлөлтийн уламжлалт найрамдлын 23 дахь сарын ажлын үеэр тус аймагт зохиогдох ЗСБНХОУ-ын Курган мужийн долоо хоногийн ажилд оролцохоор Курган мужийн Намын хорооны ахлах лектор, Философийн ухааны дэд эрдэмтэн В. А. Сорокин, ЗХУ-ын зохиолчдын холбооны гишүүн, зохиолч, сэтгүүлч В.Ф.Потанин нарын сарын 14-нд тус аймагт хүрэлцэн ирлээ. Төв аймаг, ЗСБНХОУ-ын Курган муж хоёрын хамтран ажиллах 1974 оны төлөвлөгөө ёсоор тус аймагт хүрэл-

цэн ирж байгаа Курганы зочдыг Буянт ухаагийн нисэх онгоцны буудал дээр аймгийн Намын Хорооны нарийн бичгийн дарга, МЗНН-ийн аймгийн Зөвлөлийн дарга Х. Билгээ, Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны хариуцлагатай нарийн бичгийн дарга, МЗНН-ийн аймгийн Зөвлөлийн орлогч дарга Г. Шарав, МЗНН-ийн аймгийн Зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Дэмбэрэлдаш, «Анхдугаар таван жил» сонинны хариуцлагатай эрхлэгч, МЗНН-ийн аймгийн Зөвлөлийн тэргүүлэгч гишүүн,

сэтгүүлч Д. Товуу нар угтав. Зочид Зуунмод хотод хүрэлцэн ирснийхээ дараа аймгийн ОНС музей үзэж, орой нь «Түмний эх», «Намын хорооны нарийн бичгийн дарга», «Төв аймаг 50 жилд» кино үзэж сонирхов. Мөн сарын 15-нд Курган мужийн зочид төлөөлөгчдийг аймгийн Намын Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ц.Адъяа хүлээн авч аймгийн бичгийн хөгжилтөөс танилцуулан элэгсэг дотно ярилцав. Хүлээн авч уулзахад аймгийн Намын Хорооны нарийн бичгийн (Тогсгол нь IV нүүрт)

МАХН-ЫН III ИХ ХУРАЛ ХУРАЛДСАНЫ 50 ЖИЛИЙН ОЙД

МАХН-ын III их хурал, Монгол—Зөвлөлтийн ард түмний найрамдал

Аугаа их ЗХУ-тай тогтоосон найрамдал болон тус орон эрх чөлөөгөө олж тусгаар тогтнон бүрэн эрхт байдлаа хамгаалан бэхжүүлэх эдийн засаг, соёлоо хөгжүүлэхэд ЗХУ-ын үзүүлсэн үнэлж баршгүй тусламж нь манай орон капиталист бус замаар замнан социализмд дэвшин ороход шийдвэрлэх хүчин зүйл болсон билээ.

МАХН, капиталист биш замаар улс орноо хөгжүүлэх зорилтыг дэвшүүлэн тавихдаа тэрхүү хөгжлийн үндсэн баталгаа болсон ЗХУ-тай тогтоосон найрамдлыг зүйл бүрээр бэхжүүлэхийн чухлыг онцлон заасан юм.

БНМАУ, ЗСБНХУ-ын ард түмний ангийн хэлхээ холбооны 50 гаруй жилийн гол үр дүн бол алсан пролетарийн орны тусламжтайгаар капитализмыг алгасан капитализмын өмнөх нийгмийн харилцаанаас социализмд шилжиж болох тухай В. И. Ленинний суут сургаал манай оронд хэрэгжин, биелсэн явдал мөн.

Гэтэл намын III их хурлаас энэхүү найрамдлын ангийн үндсийг бататгахад чиглэсэн тодорхой шийдвэр гаргуулахад капиталист биш хөгжлийн чиг шугамыг мөлжигч ангийн төлөөлөгчид эсэргүүцэж зөвхөн айл хөрсийн харилцааны ердийн журамд зохицуулахыг оролдож байв. Тэдний бодлого бол үндэсний явцуу шовинизмын илрэл төдийгүй Монгол—Зөвлөлтийн ард түмний хооронд тогт

сон найрамдлыг эвдэхэд чиглэсэн дэлхийн хэргис хүчний явуулгын тусгал байсан юм.

Хэдийгээр зарим нэг этгээд Монгол—Зөвлөлтийн ард түмний хооронд түүхэн ёсоор бүрэлдэн тогтсон найрамдлыг сулруулах оролдлого хийсэн боловч, МАХН-ын III их хурал түүнийг шийдвэртэй няцааж интернационалч өв уламжлалаа батгаж чадсан билээ.

Монгол-Зөвлөлтийн ард түмний ган бат найрамдал нь нийтийн дайсны эсрэг тэмцэл, социализм коммунизм байгуулалтын талбарт тохиолдсон сорилт шалгалтыг давж, үүрд орших асар их хүч чадалтай болохоо нотлон харуулж хөгжин цэцэглэсээр байна.

Тус хоёр орны ард түмний ах дүүгийн найрамдал бол манай орнуудын нийгэм улс, төр эдийн засгийн амьдрал, олон улсын харилцааны өөрчлөлт хөгжилтийн дагуу шинэ агуулга хэлбэрээр баяжин бэхжиж ирсэн юм.

Монгол-Зөвлөлтийн найрамдал БНМАУ-ыг капиталист бус замаар хөгжүүлэх, хувьсгалын нийт ардчилсан шатны зорилтыг амжилттай шийдвэрлэх тэмцлийн нэг хүчин зүйл байв.

Ардын хувьсгалын эхний арваад жилд ЗХУ-аас үзүүлсэн тусламж нь БНМАУ-ын гадаад, дотоод худалдаа, санхүүгийн шинэ систем, улсын аж үйлдвэр, тээвэр, харилцаа холбоо, хүн, малын эмнэлэг байгуулж хөгжүү

лэх, шинжлэх ухаан, үндэсний соёл урлагийг хөгжүүлэх, боловсон хүчнийг сургаж бэлтгэх явдалд чиглэгджээ.

Үүний үр дүнд БНМАУ, улс орноо капиталист бус замаар хөгжүүлэх үйлсэд том алхам хийсэн билээ.

БНМАУ-ын тусгаар тогтносон эрх чөлөөт байдалд Японы империалистууд байнга заналхийлж байсан үед БНМАУ-ын батлан хамгаалах хүчийг бүх талаар бататгахад ЗХУ ямагт туслаж байв.

Монгол-Зөвлөлтийн ах дүү ард түмэн, Японы түрэмгийлэгчид болон фашист Германы эсрэг явуулсан дайны фронт дээр мөр зэрэгцэн тулалдаж урсгасан ариун цусаараа ах дүүгийн уламжлалт найрамдлаа гэгнэн бэхжүүлж гайхамшигт ялалт байгуулсан түүхтэй.

БНМАУ-д социализмын үндэс байгуулахад болон социализмын материал техникний бат бааз байгуулах үйлсэд Зөвлөлтийн тусламж асар их үүрэг гүйцэтгэсэн бөгөөд гүйцэтгэсээр байна.

Зөвхөн сүүлийн 12 жилд ЗХУ-ын техник эдийн засгийн тусламжаар улс ардын аж ахуйн чухал ач холбогдол бүхий 150 гаруй үйлдвэр барилга байгууламж ашиглалтанд орсон бөгөөд ардын хувьсгалын 50 жилийн ойгоор 5 сургууль, 2 болон нийгэмийн бүрэн барилга, Атанбулагийн хувьсгалын музей, Улаанбаатар

(Төгсгөл нь IV дүүрт)

КОММУНИЗМЫН ОРНЫ АЛХАМ

ЗХУ-ын хүнсний үйлдвэрийн хөгжилт

Зөвлөлтийн ард түмний амьдралын төвшинг дээшлүүлэх талаар ЗХУКН-ын XXIV их хурлаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд зургаан мянга гаруй аварга том механикжсан үйлдвэр, төрөлжсөн мянга гаруй САА—г нэгтгэсэн ЗХУ-ын хүнсний алба чухал байр суурь эзэлдэг юм. IX таван жилийн эхний гурван жилд хүнсний олон зуун үйлдвэрийн газар ашиглалтад орлоо.

IX таван жилийн эхний жилүүдэд 5 миллиард рублийн хөрөнгө оруулж хүнс, мах, сүүний 700 гаруй том үйлдвэрүүд барьж байгуулан ашиглалтанд оруулав.

1965 онд 7,1 миллиард (болзолт) банк консерв, 1973 онд 13 миллиард банк консерв тус тус үйлдвэрлэжээ.

1973 онд ЗХУ-ын Хүнсний үйлдвэрийн Яамны үйлдвэрүүд, мах, сүүний үйлдвэрийн ажилчид төлөвлөгөөгөө хугацаанаас нь өмнө биелүүлэн төлөвлөгөөнөөс гадуур 1,8 миллиард рублийн бүтээгдэхүүн илүү үйлдвэрлэжээ.

ЗХУ-ын Хүнсний Яамны харъяа төрөлжсөн САА-нуудын нийт бүтээгдэхүүн 1973 онд 1970 онохоос 60 хувиар өссөний гадна САА-нууд 80 мянган тонн сүү, 10,0 мянган тонн мал мах, шувуу, 25 сая өндөг төлөвлөгөөнөөс давуулан улсад тушаажээ.

IX таван жилийн төлөв-

лөгөөний эхний 3 жилийн төлөвлөгөөг биелүүлэх үйлсэд өндөр амжилт гаргасан хүнсний болон мах, сүүний үйлдвэрийн 18,0 мянга гаруй ажилчин, албан хаагчид одон медалиар шагнагдсаны дотор 26 хүн социалист хөдөлмөрийн баатар цол хүртжээ.

Дэлгүүр мухлагуудад шинэ нөр төрлийн загасан бүтээгдэхүүн худалдаж байна.

Загасны үйлдвэрийн ажилчид 130,0 мянган тонн хүнсний загас, 28 сая банк загасан консерв, бусад бүтээгдэхүүн 90 саяыг төлөвлөгөөнөөс гадуур улсад нийлүүлэн.

Энэ оны ургацаас 4,0 миллиард гаруй банк жимс, ногооны консерв үйлдвэрлэнэ. Энэ таван жилд хүнсний мянга гаруй үйлдвэрийн газар байгуулагдана.

ЗХУ-д хүнсний их дээд 8, тусгай дунд мэргэжлийн 150 сургууль ажиллаж байгаагийн гадна хүнсний салбарт 180,0 мянган ажилчин, албан хаагчид ажиллаж байна.

ЗХУ-ын хүнсэнд 1974 онд 420 сая рублийн дээд зэргийн чанартай бүтээгдэхүүн, 470 нөр төрлийн бүтээгдэхүүнийг шинээр буюу сайжруулах, 250 бүтээгдэхүүнийг атсатчилж чанарын тэмдэг авах үүрэг амлалт аваад ажиллаж байна.

Н. ХАНДСҮРЭН

ХҮН АМЫН ЭРҮҮЛЖҮҮЛЭЛТ

Тус аймгийн нийт сум, хороодын 95,8 хувь нь их эмч, сум дундын больницны үйлчилгээнд хамрагдаж, эмчлэн сэргийлэх нийт орны 97,8 хувийг их эмчийн ор эзлэж, нэг эмчид 844 хүн оногдож аймгийн нэг иргэн жилдээ эмнэлэгт 6 удаа үзүүлэх боломжтой болов.

Мөн цусны сийвэнт 1971 оноос эхлэн аймагтаа бэлтгэдэг болдоо.

МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны 1973 оны 118 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн хүн амыг эрүүлжүүлэх талаар эмнэлгийн байгууллагууд нилээд ажил зохиов.

Энэ бүхний үр дүнд аймгийн хэмжээгээр улаан бурхан, халдварт саа, сахуу, хүүхдийн хөхүүл ханиад зэрэг халдварт өвчнүүд огт гараагүй байна.

Эмнэлгийн байгууллагын үндсэн үзүүлэлтээс орны фонд ашиглалт сайжирч дундаж ор хоног түргэсэн, жирэмсний хугацааг эрт илрүүлээд хя-

налтанд авч үйлчлэн эмнэлэгт төрүүлэх явдал сайжрав. Хүүхдийн үхлийн томоохон шалтгаан болж байсан улаан бурхан, гэдэс ходоодны замын элдэв халдварт өвчнүүдийг бууруулсны дүнд 0—1 насны хүүхдийн эндэлдэл 20 промил буюу 0,2 хувиар буурлаа.

Аймгийн төв, сум-дундын эмнэлэг, зарим их эмчийн салбаруудад идэвхтэй эмчилгээний өрөө, тасалгаа байгуулж, хүчил төрөгч, хордлогоос гаргах цус сэлбэх шингэнүүдийг өргөн хэрэглэж оношлогоо эмчилгээг эрт хийж, хүүхдийн хэсгүүдийн ажиллагаа, архаг өвчтэй хүмүүст тавих диспансерийн хяналтыг сайжруулснаар нийт хүн амын өвчлөл буурлаа.

Гэвч эмнэлгийн байгууллагуудын ажил жигд бус ажлын цэг бүрт хяналт шалгалт сул байна. Ялангуяа ариун цэврийн соёлыг хөдөлмөрчдийн дунд түгээн дэлгэрүүлж халдварт өвчнөөс урьдчилан

сэргийлэх арга хэмжээг бүрэн авч чадаагүйгээс зарим халдварт өвчнүүд нодингийн мөн үеэс ихэд төлөвтэйн дээр нилх нярай хүүхдийн эмнэлэг, арчилгаанд тодорхой амжилт гарч чадаагүй байна. Эмнэлэг урьдчилан сэргийлэх байгууллагуудын тохижилт, соёлжилт, эмнэлэг үйлчилгээнд халдварын эсрэг дэглэмийг тууштай хэрэгжүүлж, эмнэлэг хамгааллын дэглэмийг сахиулах явдал шаардлагаас хоцорч байна. Иймээс хүн амыг нийтээр нь элдэв өвчин эмнэлэг урьдчилан сэргийлэх, ариун цэвэр эрүүл ахуйн хууль дүрмийг сурталчлан биелүүлэх, хүрээлэн байгаа байгаль орчныг бохирдлоос хамгаалан эрүүлжүүлэх, хот суурин газрыг тохижуулан ногооруулах ажлыг эрчимжүүлэх нь манай эрүүл хамгаалах байгууллагуудын чухал зорилт юм. Удахгүй болох ариун цэврийн олон нийтийн байцаагч нарын аймгийн

зөвлөгөөн, МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны 1973 оны 118 дугаар тогтоолыг хэрхэн биелүүлж байгаад хийх бүх шатны депутат нарын үзлэгт эмнэлгийн байгууллага бүр идэвхтэй бэлтгэж амжилттай дүн үзүүлэх явдал шаардагдаж байна.

Эх нялхсын эрүүл мэндийг сахин хамгаалах ажилд оршиж байгаа дутагдлыг арилгахын тулд эх нялхсын үйлчилгээнд хэсгийн систем, хүүхдийн давхар хяналтанд авч үйлчлэх диспансерийн хяналтыг зааврын дагуу нэвтрүүлж, нас барсан, өвчлөл, тохиолдол бүрийг холбогдох хүмүүсийн хариуцлагатай холбон үзэж шалтгааныг илрүүлэн цаашид авах арга хэмжээг улам шуурхай гүйцэтгэвэл зохино.

Хөдөөгийн хүн амд эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламжийг улам ойртуулж хүртээмжтэй болгох, эмчлэн сэргийлэх байгууллагуудын ажиллагаанд хэсгийн системийн үйлчилгээ, диспансерчлах арга ажиллагааг тууштай

нэвтрүүлж, эмчилгээнд байгалийн шавар ус, биеийн тамир, хөдөлмөр өмчилгээ, физик эмчилгээ зэрэг эмийн бус бусад эмчилгээг зохиистой хэрэгжлээл зохино.

Эмийн сангуудын хүчин чадлыг өргөжүүлж үйлчилгээний чанар соёлжилтыг сайжруулж хөдөлмөрчдийг эм, эмнэлгийн багаж хэрэгслээр үйлчлэх, эмч мэргэжилтнүүдтэй ажиллах ажиллагааг эрс сайжруулах хэрэгтэй.

Мөн ирэх онд эмнэлгийн нийт дунд мэргэжилтэн нараас авах мэргэжлийн ахын шалгалтанд одооноос сайн бэлтгэх, үүний тулд дунд мэргэжилтэн нарыг биеэ даан системтэйгээр шалгалтанд бэлтгүүлэхэд эмнэлгийн салбарууд их анхаарвал зохино. Нам, засгаас хүн амыг эрүүлжүүлэх талаар тавьж байгаа зорилтыг ажил хэрэг болгох нь орон нутгийн нам, захиргаа, олон нийт, эмнэлгийн байгууллагуудын санаачлага бүтээлч ажлаас шалтгаална.

Ц. БАДАМ

УЛИРЛЫН АЖЛЫН ДУТУУГ УРАЛДАЖ ГҮЙЦЭЭ

Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаа, УЭ-ийн зөвлөлийн тэргүүлэгчдийн хавсарсан хурлаар сумд үйлдвэр аж ахуйн газруудын III улирлын социалист уралдааны дүнг хэлэлцэж тогтоол гаргаж.

Манай аймгийн бүтээлч хөдөлмөрчид аж ахуй соёлын бүх салбарт социалист уралдаанср жигүүлэн ажилласны дүнд улсын төлөвлөгөөт даалгавар, социалист уралдаанд авсан үүргээ амжилттай биелүүлж байна.

Эхний гурван улирлын байдлаар төл бойжилт 96,7 хувьтай байгаа ба малын зүй бус хорогдол өнгөрсөн оны мөн үеийнхээс 36 хувь буурав.

Хадлан бэлтгэх төлөвлөгөө 102,3 хувь, таван төрлийн ноосны төлөвлөгөө 108,2 хувь биелүүлж уралдааныхаа амлалтыг хангажээ. Аж үйлдвэрийн газрууд төлөвлөгөөнөөс 1,2 сая төгрөгийн бүтээгдэхүүн илүү үйлдвэрлэж төлөвлөгөө 113,4 хувиар биелүүлэв.

Одоо аймгийн хэмжээгээр V таван жилийн төлөвлөгөөг биелүүлсэн хамт олон 3, «V таван жилийн гавшгайч» тэмдэгтэн 144 байгаагийн дотор 1974 оны төлөвлөгөөг биелүүлсэн байгууллага хамт олон 4, ажилчид 179 төрж хамт олноо хошуучилж байна.

Гуравдугаар улирлын уралдаанд сумдыг төл бойжилт, малын зүй бусын хорогдол, ноос, хадлан бэлтгэл, сүү тос, мал бэлтгэлт зэрэг ажлын 27 үзүүлэлтээр цуваагаар балл өгч байр эзлүүлэхэд Угтаал сум 16 үзүүлэлтийг 100-гаас дээш хувиар биелүүлж 1 дүгээр байр, 2,3 дугаар байрыг Борнуур, Эрдэнэсант сумд авлаа.

Үйлдвэр аж ахуйн газруудыг 9 үзүүлэлтээр байр эзлүүлэхэд Хүнсний үйлдвэр 1 дүгээр байр, 2,3 дугаар байрыг Тэвэрийг удирдах газар, Хөвлөх үйлдвэр эзлэж социалист уралдаанд эхний байр эзлэсэн хамт олон

аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаа, УЭ-ийн зөвлөлийн диплом, баярын бичгээр шагнагдлаа.

1974 оны бүх ард түмний социалист уралдааныг дүгнэхэд 2 сар гаруй хан хугацаа үлдэж байгаа нь төлөвлөгөөт ажил, уралдааны үүргийн дутууг биелүүлэх хариуцлагыг ихээхэн нэмэгдүүлж байна. Одоогийн байдлаар аймгийн хэмжээгээр төмс, хүнсний ногоо бэлтгэх төлөвлөгөөг 27—53 хувь, тэжээлийн ургамал хураалт 44,6 хувь, хашаа барилт 20,2 хувь, сүү бэлтгэл 22 хувь, тарвага зурамны арьс бэлтгэлт 44,6—45,4, эрүүлийг хамгаалахын үзүүлэлтүүд 17—48,5 хувиар тус тус тасалдаж явна.

Уралдаан дүгнэхэд ахиу байр эзлэхээр үзүүлэлттэй байсан Баянцагаан сум соёл, боловсрол, эрүүлийг хамгаалах ажлын үзүүлэлтээр хангалтгүй байсан, Борнуур сум ТЭ-ний цэгээс бэлтгэлд мал өгөөгүй, мөн осол гарсан,

Дэлгэрхаан сум улсын бэлтгэлийн мах тасалсан, Бүрэн сум хадлангийн мэдээг буруу гаргасан, Бат сумбэрт осол зөрчил гарсан байдлыг харгалзан уралдааны байруудыг нь ухраасан юм.

Уралдааны амлалт үүргийн биелэлтээр Алтанбулаг, Бүрэн, Зуунмод Лүн, Эрдэнэ, Нэгдэл дундын үйлдвэр зэрэг газрууд бусад сум үйлдвэрийн сүүл барьж явна.

Иймээс дээр дурдсан тасалдлыг IV улиралд бүрэн нөхөхийн тулд нөөц бололцоогоо дайчлан социалист уралдааныг олон түмний бүтээлч идэвхи санаачлагыг өрнүүлэхүйц үр дүнтэй зохиоход сум, үйлдвэр аж ахуйн газрын уралдааны комисс, УЭ-ийн байгууллагууд анхаарч ажиллавал зохино.

Юуны урьд МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ой, манай ард түмний хамгийн хүндэт зочин анд нөхөр ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Л.И. Бреж-

невийг зочлон ирэх түүхт үйл явдлыг угтахдаа аж ахуй соёлын 1974 оны төлөвлөгөөг бүх үзүүлэлтээр нь өндөр чанартайгаар биелүүлэхэд манай өнөөгийн гол зорилт оршиж байна. Ийм учраас жилийн төлөвлөгөөг 11 дүгээр сарын 15 гэхэд биелүүлэх уриан доор социалист уралдаанд нэмэлт үүрэг авах хөдөлгөөнийг хамт олон, хувь хүн бүрийн дунд өрнүүлж Монгол-Зөвлөлтийн найрамдлын сар, аугаа их Октябрийн социалист хувьсгалын 57 жилийн ой, хүндэт зочны нэрэмжит өндөр бүтээлийн уралдааныг хэд хэдэн үе шаттай зохиож дүгнэн шинээр төрж байгаа таван жилийн гавшгайчдын амжилт туршлагыг нийтэд шуурхай мэдээлж байх нь чухал байна.

Ялангуяа мал өсгөх улсын төлөвлөгөөг биелүүлэх, малын зүй бус хороогдлыг багасган, малаж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажилтай социалист уралдааныг нягт холбон зохиох шаардлагатай байна.

Д. ТОВУУ

Статистикийн алба байгуулагдсаны 50 жилийн ойд

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭГ ҮЙЛДВЭРЛЭЛД НЭВТРҮҮЛЬ

Үйлдвэр аж ахуйн газрын эдийн засгийн үйл ажиллагааны байдлыг бүрэн харуулах улирал жилийн тайлан балансыг судлан шинжилж жилийн болон хэтийн үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөтэй харьцуулж, ололт дутагдлыг хамт олноороо хэлэлцэж зөв дүгнэлт өгч байсан газар аж ахуйгаа удирдан хөгжүүлэхэд амжилт олж байна.

Сүүлийн жилүүдийн байдалаар авч үзвэл: Холбооны газар, Хөвлөх үйлдвэр, Хүнсний үйлдвэр, Батсүмбэрийн САА, Эрдэнэсант сумын «Саруул-амьдрал» нэгдэл зэрэг газруудад үйлдвэрлэлийн болон санхүүгийн хүчин чадал нь өссөөр байна.

Судалгаа, шинжилгээг хийхдээ уул ажлын биелэлтэнд нөлөөлсөн хүчин зүйл, шалтгаан, цаг хугацаа, бусад ажлын уялдаа холбоо ямар байсан зэргийг анхаарч, ажиллах хүч, хөрөнгө материалын зарцуулалт санхүүгийн үр дүнтэй нь холбон үзэх ёстой. Судалж шинжлэх дүгнэлт хийхэд олон жилээр хийгдсэн зэрэгцүүлэлт түүний дунджийг ашиглаж зарим онцлог үед гарсан өөрчлөлтийн нөлөөллийг арилгах шаардлагатай.

Аж ахуйг удирдахад зөвхөн цаг үеийн төлөвлөгөөт ажлын биелэлт, улирал жилийн тайлан балансанд судалгаа дүг-

нэлт өгөөд зогсохгүй өргөн хүрээтэй эдийн засгийн олон үзэгдлийг судлан шинжлэх хэрэгтэй.

Сумдын АДХ-ын гүйцэтгэх захиргаанд улс ардын аж ахуй соёлыг хөгжүүлэх бүх төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлийн динамик эдийн засгийн паспорт зэрэг судалгааны маягт хөтлөгдөж байна.

Судалгааг аймаг, сумын дүнгээр гаргаад зогсохгүй суурь, бригад, хүн, үйлдвэрлэлийн нэгж үзүүлэлт бүрээр гаргах нь үр дүнтэй.

МАХН-ын Төв Хорооны V бүгд хурлын шийдвэрийг биелүүлэхийн тулд Статистикийн товчоо, аймгийн улс ардын аж ахуй соёлын хөгжилтийн тоо материалыг 1970 оноос хойш чанарын талаас нь нэгтгэн судалж, үйлдвэрлэлийн үндсэн ба эргэлтийн хөрөнгийн ашиглалт хөдөлмөрийн бүтээмж дундаж цалингийн уялдаа өөрийн өртгийн хямдралт, таваарын бүтээгдэхүүний борлуулалт, ашигт ажиллагааны түвшин, нэг малаас ашигласан ашиг шим, гагаас авсан ургац, 1000 хүн амд ноогдох соёл боловсрол, эрүүлийг хамгаалахын гол үзүүлэлтүүдийг тусгаж байна.

1971—1973 оны нийт ба цэвэр бүтээгдэхүүнийг салбаруудын ба хуваарилтын аргаар тооцож аймгийн дүнгээр нэгтгэсэн нь зохих хэмжээний

онол практикийн мэдлэгийг товчооны хамт олноос шаардсан судалгаа шинжилгээний томоохон ажил юм.

Дээрхи судалгаанаас үзвэл 1973 оны 1971 онтой харьцуулахад аймгийн нийт бүтээгдэхүүн 31,9 хувиар, цэвэр бүтээгдэхүүн 18,3 хувиар өсчээ.

Ер нь эдийн засгийн тодорхой мэдлэггүй үйлдвэрлэлийн эдийн засаг санхүүгийн хүч чадал нөөц бололцоог нарийн судалж үзэхгүйгээр аж ахуйг хэтийн төлөвлөгөөтэй зүй зохистойгоор хөгжүүлж чадахгүй нь мэдээж.

Ийм учраас бүртгэл эдийн засгийн мэргэжилтэн, үйлдвэр аж ахуйн газрын дарга, албан хариуцлагатай нар аж ахуйгаа үнэн зөв бүртгэж судалсан тооцоо судалгааны үндсэн дээр хөтлөн удирдахын тулд эдийн засгийн мэдлэг боловсрол, судлаж, шинжлэх, дүгнэлт өгөх чадвараа дээшлүүлэхэд байнга анхаарах хэрэгтэй.

Санхүү—эдийн засгийн мэргэжилтэн нараас тайлан балансын үр дүнг судлан шинжилж хамт олон зөвлөгөөнөөр хэлэлцүүлж зохих арга хэмжээг авч судалгаа шинжилгээний ажлын үр дүнг улам сайжруулах нь чухал байна.

Ц. БЯМБАА

ИРГЭНИЙ ХАМГААЛАЛТЫН ШТАБ

Иргэний хамгаалалтын бүх сургалт, зохион байгуулалт, олон түмнийг төлөрүүлэн удирдах гол хүч нь бүх шатны штабууд юм.

Иргэний хамгаалалтын штаб нь даргын дэргэд байгуулагдсан удирдлагын байгууллага юм.

Штаб нь иргэний хамгаалалтын байлдааны бэлэн байдлыг хангах төлөвлөгөө боловсруулж түүнийг биелүүлэх ажлыг зохион байгуулан тасралтгүй удирдлагаар хангаж мэргэжлийн ангиудын сургалтыг шаардлагын дагуу явуулах үүрэгтэй.

Сум, хот, хороодын иргэний хамгаалалтын штабууд орон тооны бус зохих мэргэжлийн боловсон хүчинтэйгээр байгуулагдан ажиллаж байна.

Сэргэлэн, Угтаал, Баян, Эрдэнэсант сумд штабын ба штаб командын сургуулийг явуулж ихэнх мэргэжлийн албад, штаб үүрэг зорилтынхоо талаар зохих мэдлэгтэй болж улс ардын аж ахуйн цаг үеийн зорилттой иргэний хамгаалалтын ажлыг зөв хослон явуулж тодорхой үр дүнд хүрчээ.

Мал ургамал хамгаалах албан (штабын дарга нь Галданжамц) малын бэлчээр цэвэрлэх, тэжээл бэлтгэх, урьдчилан сэргийлэх ажлыг иргэний хамгаалалтын ажилтай зөв хослон явуулжээ.

Гэвч сум, хот хороодын иргэний хамгаалалтын штабын ажил жигд биш байна.

Штаб нь ямарч цагийн байдалд иргэний хамгаалалтын олон талт үйл ажиллагааг итгэлт төгс, шуурхай удирдаж чадах аппарат байх ёстой.

Штабын ажлын нэн чухал хэсэг нь төлөвлөлт юм. Иргэний хамгаалалтын төлөвлөлт нь бүх талаар шалгагдсан бодит үндэслэлтэй байх хэрэгтэй.

Иргэний хамгаалалтын штабууд нам, улс, олон нийтийн байгууллагуудтай холбоотой ажиллаж иргэний хамгаалалтын сургалт нэвтрүүлэг, ухуулга мэргэжлийн дэмжлэг туслалцааг байнга авч байвал зохино.

Штабын бүх ажилд хатуу зохион байгуулалт дэг журам сахилга бат хэвшсэн байх ёстой.

Энэ нь штабын ажилтны боловсрол ажил хэргийн мэдлэг, бүтээлч санаачлагаас хамаарна.

Иймээс сум, хот, хороодын иргэний хамгаалалтын ажилтан бүр эрхэлсэн ажлын мэргэжил мэдлэг, Марксист—Ленинист онол цэргийн хэргийн ба эдийн засгийн боловсролоо дээшлүүлэхэд биеэ дайчлан ажиллах хэрэгтэй.

Бүх ард түмний үйлс болсон иргэний хамгаалалтын системийг бэхжүүлж МАХН-аас тавьж байгаа шаардлагын хэмжээнд хүртэл сайжруулах явдал сум, хот хороодын иргэний хамгаалалтын штабын эрхэм үүрэг мөн.

Ж. СҮНДУЙ

ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ШААРДЛАГА ХАНГАЯ

Саяхан тус аймагт МҮЭ-ийн Төв Зөвлөлийн хөдөлмөр хамгааллын улсын байцаагчдын групп шалгалт явагдаж түүнд 40 гаруй байгууллага хамрагдав.

Ихэнх үйлдвэр, аж ахуй, соёлын байгууллагууд дэлгт амжилттай дүн үзүүлсний дотор Жаргалантын САА, Хүнсний үйлдвэр зэрэг газрууд хөдөлмөрийн хууль тогтоомж, зохих дүрэм заавруудыг сурталчлах, биелүүлэх ажлыг сайн зохион байгуулжээ.

Гэвч үйлдвэр, аж ахуй, соёлын зарим байгууллагуудад ажилчдын хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулах, хөдөлмөр хамгааллын хууль тогтоомжууд, аюулгүй ажиллагааны арга барилын дүрэм заавруудыг сурталчилан биелүүлэх ажил хангалтгүй, хууль тогтоомжуудыг зөрчиж байгаа дутагдал илэрлээ.

Аймгийн Сонинны үйлдвэр, НААУ-ний газрын төмөр, гутлын тасаг, угаалын цехэд байрны багтаамж муу, Хотын худалдааны трестийн дэлгүүр, гуанзнуудад гэрэлтүүлэг хүрэлцээгүй, ясли, цэцэр-

лэгүүд, Барилга угсралтын контор, ажилчдын орон сууц, Угтаалын САА-н тэжээлийн үйлдвэрт бохир усны системийг шингэлтанд оруулалгүйгээр барилгыг хүлээн авч ашиглаж байгаа Нэгдсэн больниц, Нэгдэл дундын үйлдвэрийн олон өрөө, тасалгаа гэрэлтүүлэг дутуу, гэрлийн унтралгаа байхгүй, утасны үзүүр ил задгай байв.

Зарим САА, үйлдвэр,

ажил хангалтгүй байна. Ийм байдлаас болж үйлдвэрлэлтэй холбогдсон ослын тоо тууштай буурч чадаагүйгээр барахгүй Нэгдэл дундын үйлдвэр зэрэг газруудад хүний амь үрэгдсэн осол гарсан байхад ослыг дахин гаргахгүй байх талаар тодорхой ажил зохиогоогүй, БУК, Хотын худалдааны трест, Авто тээврийн ХП бааз зэрэг газруудад ослын актыг

насанд хүрээгүй хүмүүсийг шөнийн ээлжинд ажиллуулах, тэдний өргөх, зөөх ачааны хүндийн хэмжээг хэтрүүлэх, хөдөлмөрийн хүнд хортой нөхцөлд ажиллаж байгаа ажилчдын нормын сүү, саванг тасалдуулах, шөнийн цагт хортой нөхцөлд ажилласны нэмэгдэл цалин болон мөн ажилчин албан хаагчдад нэмэгдэл амралт олгох журам зөрчигдөж байна.

ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ҮЗЛЭГИЙН ДҮН

аж ахуйн газруудад техник механизм паспортгүй, паспортын хөтлөлт хангалтгүй техникийн хаалт, цахилгаан тоноглолуудын хамгаалалт, газардуулга дутуу, анхааруулга саниамж дохиотой болгох ажил хангалтгүй байлаа.

Осол гэмтэлгүй ажиллахын тулд ажиллагсдыг аюулгүй ажиллагааны арга барилд сурган зааварлах ажил жигд биш, ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгслэл олголт, хэрэглүүлж хэвшүүлэх хуучин хувцас хэрэгслэлийг угаах ариутгах

цаг тухайд нь тогтоолгүй ослыг нуун дарагдуулсан ноцтой дутагдал ч байна.

Зарим үйлдвэр, аж ахуйн газрын дарга, эрхлэгчид, инженер техникийн ажилтнуудын хууль эрхийн мэдлэг хангалтгүй байгаа нь үзлэгийн явцад харагдав.

Үүний жишээнд Нэгдэл дундын үйлдвэрийн инженер Эрднээг дурьдаж болно.

Тус аймагт түр ба улирлын чанартай ажилчдыг ажилд авах, ажлаас халах журам, эмгэгтэйчүүд,

Хөдөлмөрийн гэрээ байгуулах, цуцлахдаа ҮЭ-ийн хорооны зөвшөөрөл авахгүй ажилчдыг ажлаас дур мэдэн халж хууль тогтоомж зөрчин ажилчин хүнийг хохироож байгаа дутагдал ч байна.

Төвийн 8 жилийн дунд сургуулийн захиргаа, ҮЭ-ийн хорооны зөвшөөрөлгүйгээр 10 гаруй хүн ажлаас халсан, тахир дутуугийн 2 дугаар групптэй хүнийг уурин зууханд засварчнаар авч ажиллуулах зэргээр хөдөлмөрийн хууль тогтоомжийг зөрчжээ.

Хөдөлмөрийн хууль тогтоомжуудад ажилчин албан хаагчдыг зөвхөн онцгой тохиолдолд ҮЭ-ийн хорооны зөвшөөрөлтэйгөөр илүү цагаар ажиллуулах ёстой атал Зуунмод хотын худалдааны трестийн нийтийн хоолны газрууд ажилчдыг илүү цагаар ажиллуулахдаа ҮЭ-ийн хорооны зөвшөөрөлгүй ажиллуулж байсан нь шалгалтаар илрэв. Үйлдвэр аж ахуйн газар бүр хөдөлмөрийн маргаан таслах комисс байгуулж ажиллуулах, хүмүүсийн өргөдөл гомдлыг барагдуулж байх, удирдах ажилтан, инженер техникийн ажилтнуудын хууль эрх хөдөлмөр хамгааллын мэдлэгийг дээшлүүлэн шалгалт авах ажлыг тогтмолжуулах шаардлагатай байна.

Үзлэгээр илэрсэн дутагдал зөрчлүүдийг арилган хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны арга барилын дүрэм заавруудыг ширхэглэн биелүүлж осол гэмтэлгүй хамт олон болох хөдөлгөөнийг өрнүүлэх явдал чухал байна.

Хөдөлмөр хамгааллын улсын байцаагч
Ш. БАТТУЛГА

КУРГАНЫ ЗОЧИД МАНАЙ АЙМАГТ

Төгсгөл. (Түрүүч нь

II нүүрт)

дарга, МЗНН-ийн аймгийн Зөвлөлийн дарга Х. Билэгэ, Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны хариуцлагатай нарийн бичгийн дарга, МЗНН-ийн аймгийн Зөвлөлийн орлогч дарга Г. Шарав, МЗНН-ийн аймгийн Зөвлөлийн нарийн бичгийн дарга Д. Дэмбэрэлдэ, «Анхдугаар таван жил» сонинны хариуцлагатай эрхлэгч, МЗНН-ийн аймгийн Зөвлөлийн тэргүүлэгч гишүүн Д. Товуу нар байлцав. Мөн өдөр аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны ХААУ-гаарын дарга М. Нямаа, Курганы тө

лөөлөгчдийг хүлээн авч уулзан аймгийн ХАА-н хөгжилтөөс ярьж танилцуулав. Дараа нь зочид НААУ-ний газар, Урчуудын салбар, «Анхдугаар таван жил» сонинны СХ-ийн хэвлэх үйлдвэр, Төвийн 10 жилийн дунд сургуулиар орж ажил байдалтай нь танилцав.

Үйлдвэрийн газрууд төлөвлөгөөт зорилтоо амжилттай биелүүлж байгааг зочид өндөр үнэлээд тэдэнд улам их амжилт хүсэн өрөөв. Мөн тэргүүний хүмүүсийн ажлын арга туршлагыг ихэд сонирхохын хамт Курган нутгийнхаа амьдрал, ажлын туршлагаас ярьж танилцуулсаар явав.

Түүнчилэн ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Л.И.Брежнев манай оронд айлчлах гэж байгаа баярт үйл явдлыг угтаж Социал-демократид нэмэлт үүрэг авч, түүнээ хэрэгжүүлж байгаа гавшгайчдад манай хүндэт зочид чин сэтгэлийн халуун талархал илэрхийлэв.

Орой нь Курган мужийн Намын хорооны ахлах лектор, философийн ухааны дэд эрдэмтэн В. А. Сорокин «IX таван жилийн төлөвлөгөө биелүүлэхэд Курганы хөдөлмөрчдийн тэмцэл» гэсэн сэдвээр Зуунмод хотын хөдөлмөрчдөд лекц уншлаа.

Ш. ЦЭРЭНДОО

МАХН-ын III их хурал, Монгол—Зөвлөлтийн ард түмний найрамдал

Төгсгөл. (Түрүүч нь

II нүүрт)

дахь хүүхдийн сүү тэжээлийн газрыг тус оронд бэлэглэсэн юм.

Хагас зуу гаруй жилийн турш ариун тунгалаг бат оршиж мөнхжсөн Монгол—Зөвлөлтийн ард түмний ах дүүгийн найрамдал, хамтын ажиллагааны хэлбэрэлтгүй бэхжилт нь пролетарийн интернационализмын зарчимд тулгуурласан найрамдлын аугаа их хүчин чадлыг дэлхий нийтэд илтгэн харуулсаар байна.

Үүний нэг тод илрэл бол ЗХУКН, Зөвлөлт засгийн газраас БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойг тохиолдуулан ЗХУ-аас манай оронд үзүүлэхээр болсон шинэ их тусламж юм.

Түүхт ойт тохиолдуулан ЗХУ-аас манай орны улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэхэд нэмэлт хувь нэмэр болгож дотуур байр, багш нарын сууц бүхий тус бүр 964 хүүхэд су-

ралцах иж бүрэн 2 сургуулийн барилда, жилдээ 70 мянган хавтгай дөрвөлжин метр талбайтай орон сууц барих чадалтай байшин үйлдвэрлэх комбинат барьж өгөх ба 15 сая рублийн үнэ бүхий өргөн хэрэгцээний бараа таваар нийлүүлэх бөгөөд тус орны радио нэвтрүүлгийн хэрэгслийг хөгжүүлэхэд зориулан 60 сая рублийн буцалтгүй тусламж үзүүлнэ.

Ийнхүү ЗХУ-тай тогтоосон найрамдал, хамтын ажиллагаа бол Монголын ард түмний түүхэн амжилт ялалтын шийдвэрлэх хүчин зүйл болсоор ирсэн, болсоор ч байна.

Ийм ч учраас манай ард түмэн Зөвлөлтийн баатарлаг ард түмнийг «Гарыг нь ганзаганд хөлийг нь дөрөөндөд хүргэсэн ачит ах, эгч нартайгаа зүйрлэн үзэж байр талархалыхаа дээдлийг өргөн дэвшүүлж байдаг юм».

З. БАЯРБАТ

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д. ТОВУУ

З А Р Л А Л

Улаанбаатар хотын сугалааны эдийн хонжворыг Улаанбаатар хот дахь Улсын их дэлгүүрээс, мөнгөн хонжворыг аймгийн банк ба тооцооны кассуудаас тус тус 11 дүгээр сарын 20 хүртэл олгохыг мэдэгдье. Хугацаа хожимдвол олгохгүй.

Аймгийн санхүүгийн хэлтэс

(Х-02438)

«Анхдугаар таван жил» сонинны СХ-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.